



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 50

Мандалговь

Хөрөнгө шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арваннэгдүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Говь-Угтаал сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2022 онд барьж ашиглалтад оруулсан нийт 64,996,453 (жаран дөрвөн сая есөн зуун ерэн зургаан мянга дөрвөн зуун тавин гурван) төгрөгийн төсөвт өртөгтэй 0.4 кв-ын цахилгаан шугамын өргөтгөлийг мэргэжлийн байгууллага болох “Багануур Зүүн Өмнөд Бүсийн Цахилгаан Түгээх Сүлжээ Төрийн Өмчит Хувьцаат Компанийн Говьсүмбэр салбар”-ын өмчид шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон цахилгаан хангамжийн барилга байгууламжийг төрийн өмчид шилжүүлэх ажлыг зохих хууль тогтоомж, журмын дагуу шийдвэрлүүлэхийг Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Адьяасүрэн)-д даалгасугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  СӨД-ЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн
50 дугаар тогтоолын хавсралт

Говь-Угтаал сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар
хийгдсэн цахилгаан шугамын барилга байгууламжийн жагсаалт

№	Барилга байгууламжийн нэр	Төсөвт өртөг/төгрөг/
1	Говь-Угтаал сумын шинэ суурьшлын бүсэд 0.4 квт цахилгаан шугамын өргөтгөл	64,996,453
Нийт дүн		64,996,453 (жаран дөрвөн сая есөн зуун ерэн зургаан мянга дөрвөн зуун тавин гурван) төгрөг